ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 26 өдөр　　　　Дугаар А/188　　　　Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалт, 2024 оны 03 дугаар сарын 25-ны даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж, тайланг Авлигатай тэмцэх газарт хуульд заасан хугацаанд хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газарт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ　　　　О.БАТТУЛГА

1424105О1

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын
2024 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн
А/183 дугаар тушаалын хавсралт

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Төсөв | Хамтран хариуцах албан тушаалтны нэр |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | |
| 1.1 | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх | - Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>- Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>- Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>- Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | -АТГ-ын УССГХ-ээс бүтээсэн 7 контентыг байгууллагын албан ёсны сайтад байршуулсан байна. | Жилдээ | 0 | Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах ажилтан Д.Жавхлан |
| 1.2 | Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | - Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>- Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>- Үр дүнг тооцсон байх. | -Орон нутгийн Биеийн, тамир, спортын салбарын 80-аас доошгүй ажилтан, албан хаагчдаас "Байгууллагын үйл ажиллагааны талаар"-санал хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн үйл ажиллагаандаа тусгасан байна. | Жилдээ | 0 | БТБХХ-ийн дарга О.Баасан, ЭБАТ Б.Нармөнх |
| 1.3 | Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт | - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>- Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү | -Салбарын статистикийн эмхэтгэл, 100 жилийн ойн ном товхимолд авлигын хор хөнөөлийг иргэдэд | Жилдээ | 0 | Салбарын статистикийн мэдээлэл, бүртгэл, шинжилгээ хариуцсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>- Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>- Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан байна. | | | мэргэжилтэн Б.Ганзориг, Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн С.Номин |
| 1.4 | Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | - Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>- Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>- Олон нийтэд түгээсэн байх. | АТГ-ын УССГХ-тэй хамтран Спортын салбарт Авлигаас ангид байхад чиглэсэн 2-оос доошгүй контент бүтээсэн байна. | Жилдээ | 6,000,000 | Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Э.Билэгт, ЭБАТ Б.Нармөнх |
| Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | | | | | | |
| 2.1 | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх; | - Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>- Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;<br>- Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;<br>- Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх | - Байгууллагын албан ёсны www.sport.gov.mn цахим хаягт олон нийтийн хяналтын оролцоог хэрэгжүүлнэ.<br>-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдалд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, тайлан, мэдээг үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна. | Жилдээ | 2,000,000 | СХОХ-ийн дарга Д.Цэрэнболд, ГХМТХ-ийн дарга Н.Оюунбат, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баттогтох, ЭБАТ Б.Нармөнх |
| 2.2 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | - Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; | -Үндэсний шигшээ багийн спортын 25 холбоодын нэгдсэн судалгааг АТГ-ын | Жилдээ | 0 | Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;<br>- Үр дүнг тооцож, тайлагнасан байх | УССГХ-т хүргүүлсэн байна.<br>-Улсын төсвөөс санхүүжилт авсан спорт холбоодын удирдлагад Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. | | | Э.Билэгт, ЭБАТ Б.Нармөнх |
| 2.3 | Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | - 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх;<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах;<br>- Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | -Байгууллагын албан ёсны сайтад 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээг оруулах<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүнийг оролцуулсан байна.<br>- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг тооцсон байна. | Жилдээ | 0 | Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд, ЭБАТ Б.Нармөнх |
| 2.4 | Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ | - Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>- Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; | Тухайн жилийн байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн | Жилдээ | 0 | Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баттогтох, Бичиг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | - Олон нийтэд түгээсэн байх. | мэдээнд дүн шинжилгээ хийж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тус бүрээр гаргаж, байгууллагын албан ёсны сайтад улирал бүр байршуулсан байна. | | | хэргийн ажилтан Э.Мөнгөнцэцэг |
| Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | |
| 3.1 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>- Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | -Салбарын мэдээллийн цахим системийн чанар, хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын албан ёсны сайтаар дамжуулан авсан байна. | Жилдээ | 0 | Салбарын мэдээлэл, технологийн бодлогын зохицуулалт, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Лхагваням |
| 3.2 | Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх; | - Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>- Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>- Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх; | -Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг батлуулсан байна.<br>-Байгууллагын үйл ажиллагаанд Авлигын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.<br>- Шинээр томилогдсон албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор АТГ-ын сургалтад хамруулсан байна. | Жилдээ | 0 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Н.Батсүх ЭБАТ Б.Нармөнх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх | - Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх;<br>- Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх;<br>- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх;<br>- Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх. | -Байгууллагын үйл ажиллагаанд Авлигын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, үр дүнг байгууллагын албан ёсны сайтад байршуулсан байна.<br>-Шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.<br>-2023 онд ирүүлсэн зөвлөмж, УССГХ-тэй хийсэн уулзалтын мөрөөр арга хэмжээ авч, зөрчлийг арилгасан байна. | Жилдээ | 0 | ЭБАТ Б.Нармөнх |

ХЯНАСАН:ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б. Баттогтох Б.БАТТОГТОХ

БОЛОВСРУУЛСАН: АГЕНТЛАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б. Нармөнх Б.НАРМӨНХ